



МАСКАА ЗҮҮЕ



ГАРАА УГААЯ



ЗАЙГАА БАРЬЯ



УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД



MILLENNIUM
CHALLENGE CORPORATION
UNITED STATES OF AMERICA

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (05)

2021.02.01

УСУГ, ОСНААУГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН УЛСЫН УСНЫ АССОЦИАЦААС БОЛОВСРУУЛСАН AQUARATING АРГАЧЛАЛААР ҮНЭЛЖ, ГЭРЧИЛГЭЭ ОЛГОЛОО



Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээний санхүүжилтээр хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд үйл ажиллагааны хүрээнд Ус сувгийн удирдах газар (УСУГ) болон Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар (ОСНААУГ)-ын үйл ажиллагааг Олон улсын усны ассоциацаас боловсруулсан AquaRating аргачлалаар үнэлсэн бөгөөд үнэлгээний тайланг танилцуулж, гэрчилгээ гардуулах ёслолыг цахимаар зохион байгууллаа. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн AquaRating аргачлал нь ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг үндсэн найман чиглэлээр үнэлж, дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах чиглэлүүдийг тодорхойлж өгдөг бөгөөд усны үйлчилгээний чанарыг шинэ төвшинд гаргах, үйл ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулахад чухал ач холбогдолтой юм.

[Эх сурвалж: Монголын Мянганы сорилтын сан, Монголын Мэдээ](#)

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БУГАНТ ТОСГОН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖТАЙ БОЛЛОО



Сэлэнгэ аймгийн Бугант тосгонд хоногт 250 метр куб бохир ус цэвэрлэх хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж ашиглалтад орлоо. Ариутгах татуургын энэхүү байгууламж нь бүрэн автомат ажиллагаатай аж. Бохир усыг биологийн аргаар халдаргүйжүүлэн 80 хүртэл хувиар цэвэршүүлэх хүчин чадалтай. Мөн шүүгдэж гарсан саарал усыг техникийн хэрэгцээнд ашиглахаас гадна лагийг дахин боловсруулж, усгүйжүүлсэн лагийг газар тариалан, хөрсний бордоогоор ашиглах боломж бүрджээ. Бугант тосгон аймгийн төв болон Улаанбаатар хотоос алсдагдсан хэдий ч 3000 гаруй хүн амтай томоохон суурин. Энэ тосгоны оршин суугчдын 30-аад хувь нь төвлөрсөн орон сууцанд амьдардаг байна. Иймээс эдний цэвэрлэх байгууламж нь олон жил болсон учраас шаардлага хангахаа больжээ. Ингэснээр бохир усыг цэвэрлэхгүйгээр гадагшлуулдаг, бохир ус хальдаг зэрэг хүндрэлүүд үүссэн байсан. Түүнчлэн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж эхэлжээ.

[Эх сурвалж: МОНЦАМЭ, Монголын Мэдээ](#)

“УСНЫ ТУХАЙ ХУУЛЬ”, “УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙГ ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ЭЭЛЖИТ СУРГАЛТАА ЦАХИМААР ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын Усны хяналт шинжилгээний хэлтсээс “Усны тухай хууль”, “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх, усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг бууруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур орчны шинжилгээний газрын харьяа Байгаль-орчны итгэмлэгжлэгдсэн лаборатори, 21 аймгийн лабораториудын холбогдох мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ээлжит сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулав. Усны газрын дарга Ш.Мягмар сургалтын эхэнд Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгөв. Мөн “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль”, түүнийг дагалдан гарсан дүрэм, журмын хэрэгжилт, сэдвээр Усны газрын Усны хяналт шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн Л.Хишигдулам, “Хаягдал бохир усны сорьц авах, шинжилгээ хийх” сэдвээр тус хэлтсийн мэргэжилтэн Д.Мөнхзул нар танилцуулга хийж, оролцогчдын сонирхсон асуултад хариулт өгч санал солилцлоо.

[Эх сурвалж: Усны газрын албан ёсны Фэйсбүүк хүүдас](#)

ГАЗРЫН ДООРХ УСНЫ СУДЛААЧ, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХАМГИЙН ТОМ ЦАХИМ ЦУГЛАРАЛТАД ОРОЛЦООРОЙ!



Газрын доорх усны талаар мэдлэг, мэдээллийг түгээх зорилго бүхий “The Groundwater Project” олон улсын төрийн бус байгууллагаас 2021 оны хоёрдугаар сарын 3-26-ны хооронд буюу энэ долоо хоногийн лхагва гаригаас эхлэн гурван долоо хоногийн турш дэлхийн гидрогеологийн салбарын шилдэг судлаач, эрдэмтдийн газрын доорх усны шинэ тутам судалгааны бүтээлүүдийг хэлэлцүүлэх цахим уулзалт, хэлэлцүүлгүүдийг цувралаар зохион байгуулах гэж байна. Арга хэмжээг “The Groundwater Project” байгууллагын YouTube сувгаар хүргэх бөгөөд илтгэгчидтэй шууд холбогдож харилцах, сонирхсон асуултаа хариулт авах боломжтой байх юм. Тус байгууллага энэ удаад дэлхийн газрын доорх усны судлаач, мэргэжилтнүүдийн хамгийн том цахим цугларалтыг зохион байгуулж, хоорондоо холбоо харилцаа тогтоон мэдлэг, туршлагаа солилцох боломжийг бүрдүүлэхээр зорьж байгаа аж. Дараах холбоосоор хөтөлбөртэй танилцан үнэгүй бүртгүүлж, оролцох боломжтой: <https://events.gw-project.org/2021>

[Эх сурвалж: https://events.gw-project.org/2021](https://events.gw-project.org/2021)